



The AMERICAN CHAMBER of Commerce in Mongolia

Хэвлэлийн мэдээ
26.08.2019

Холбоо барих
+976 9511 7771

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга АмЧам Монголын гишүүд болон хөрөнгө оруулагчидтай уулзлаа

УЛААНБААТАР – Монгол дахь Америкийн Худалдааны Танхим (АмЧам) нь Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга АмЧам Монголын гишүүд болон хөрөнгө оруулагчидтай хийх уулзалтыг 2019 оны 8-р сарын 26-ны Даваа гаригт зохион байгууллаа. Монгол Улсын Ерөнхийлөгч Х. Баттулгын Америкийн Нэгдсэн Улсад өнгөрсөн сард хийсэн айлчлал амжилттай болж хоёр орны хамтын ажиллагаа шинэ шатанд гарч буйг Монгол дахь Америкийн худалдааны танхим (АмЧам Монгол) талархан хүлээн авсан бөгөөд айлчлалтай уялдуулан “Монгол-Америкийн харилцаа: Стратегийн түншлэлд тулгуурлан урагшлах нь” сэдвээр энэ сарын бизнес уулзалтаа зохион байгууллаа.

АмЧамын энэ удаагийн уулзалтаар стратегийн түншлэл нь бизнесийн орчинд хэрхэн нөлөөлөх, хоёр орны худалдаа, эдийн засгийг хөгжүүлэх ямар боломж гарч ирж байгаа талаар ярилцлаа. Уулзалтад хөрөнгө оруулагчид, олон улсын банк, санхүүгийн байгууллагын болон Монгол дахь элчин сайдын яамдын төлөөлөгчид оролцож Ерөнхийлөгчтэй илэн далангуй санал солилцож сонирхсон асуултандаа хариулт авлаа.

АмЧам Монголын ТУЗ-ийн дэд дарга Гари Биондо нээлтийн үгэндээ, “Ерөнхийлөгч манай арга хэмжээнд оролцож байгаад бид маш баяртай байна. АмЧам Монголын зүгээс Стратегийн түншлэлийг эрчимжүүлэхэд бүхий талаар дэмжиж оролцоход бэлэн байна” гэв.

АНУ-ын Элчин сайд Майкл Клечески үг хэлэхдээ “АмЧам Монголын бизнесийн орчинг сайжруулж, хувийн хэвшлийг хөгжүүлэхэд томоохон хувь нэмэр оруулдагт АНУ-ын элчин сайдын яам талархдаг. 2017 болон 2018 онуудад хоёр орны худалдааны эргэлт 130 сая ам.доллар байсан бол энэ оны эхний зургаан сарын байдлаар 133 сая ам.долларт хүрч өмнөх жилүүдээс 43 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Худалдааны эргэлтийг нэмэгдүүлэхэд хүчин чармайлт гаргаж тэртээ 2012 онд 707 сая ам.доллар хүрч байсан төвшнөөс давуулах зорилго тавьж ажиллаж байна.” хэмээсэн юм.

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга хэлсэн үгэндээ “Америкийн Нэгдсэн Улс нь бидний хувьд чухал “гуравдагч хөрш”, улс төр, эдийн засгийн ойрын түнш мөн. Технологи үйлдвэрлэлийн дэлхийн тэргүүлэгч улс, худалдааны том тоглогч, гадаадын хөрөнгө оруулалтын арвин эх үүсвэр болдог АНУ-тай худалдаа, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааг илүү өндөр түвшинд хөгжүүлэхийг бид чухалчлан үзэж байгаа. АмЧам хөрөнгө оруулагчдыг холбох ажлууд хийнэ гэж найдаж байна.

Шат ахиулсан түншлэл маань хоёр улсын харилцааг бүхий л салбарт өргөжүүлэн бэхжүүлэх, ялангуяа чамлалттай байгаа худалдаа, хөрөнгө оруулалт, эдийн засгийн хамтын ажиллагааг сайжруулах, нэмэгдүүлэх чухал хөшүүрэг болох учиртай. Хоёр орны худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг идэвхжүүлэхэд “public diplomacy” буюу хувь хүмүүс, олон нийтийн болон бизнесийн байгууллагуудын хоорондын харилцаа илүү нөлөөлөл, үүрэгтэй билээ. Та бүхэнтэй санал солилцож, “Стратегийн түншлэл”-ийн харилцаагаа эдийн засгийн агуулгаар баяжуулахад хамтран ажиллахад бэлэн байна” гэсэн юм.

АмЧам Монголын тухай

АмЧам Монгол нь АНУ-Монгол Улс хоорондын бизнесийн түншлэлийг өргөжүүлэх, бэхжүүлэх, эрх ашгийг нь хамгаалах болон Америкийн хөрөнгө оруулалтыг Монголд татах чиглэлээр ажилладаг бие даасан, гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага юм. АмЧам Монгол нь 3 сая гаруй гишүүдтэй дэлхийн хамгийн том бизнесийн холбоонд тооцогддог Америкийн Худалдааны Танхимын албан ёсны салбар юм. Мөн АмЧам Монгол нь Ази Номхон далайн 29 орнуудын Америкийн худалдааны танхимуудыг нэгтгэдэг Ази Номхон далайн орнуудын Америкийн Худалдааны Танхимуудын Зөвлөл байгууллагын гишүүн юм.